



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/244

Хэрлэн сум

Ж.Мядагмаад буцалтгүй тусламж  
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.2, 40.2.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш Ж.Мядагмаагийн тавьсан хүсэлтийн дагуу тус сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдын хэрэгжүүлж буй “Зүгээр битгий хая” аяны хүрээнд 20 сурагчийг Улаанбаатар хотод гялгар уут дахин боловсруулах “Пластик центр” ХХК, хуванцар сав, хөнгөн цагаан дахин боловсруулах “Ти эм эл” ХХК-ийн үйлдвэрүүдтэй танилцах, туршлага судлах үйл ажиллагааны зардалд 500,000 (таван зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

202109051